



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТУГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/105/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Лхагвацэнд
Утас: 260512 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn
Аудитор: П.Цогзолмаа
Утас: 261628 Цахим хаяг: tsogzolmaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "ЦЭБЭ Консалтинг аудит"
ХХК-ийн Захирал: Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. Аудитын илрүүлэлт	14
5.1 Албан шаардлага.....	14
5.2 Зөвлөмж.....	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	16
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН
ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АМАРСАНАА ТАНАА

2024.03.15 № 07/742
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад илрээгүй ба материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

"Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим программын хөгжүүлэлт"-ийн ажил, Вэб хуудсыг архивлаж, мэдээллийг ил тод нээлттэй болгох хөгжүүлэлтийн ажил, ERP хөгжүүлэлтийн ажил, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил бүрэн хийгдэж дууссан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Z:\Yawsan_Bichig\2024\03\15 SNAG 35 Docx

0001051481

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 сарын 19-ны өдрийн 556 тоот тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 21 нэр төрлийн 82 ширхэг 794.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэснийг санхүүгийн тайланд толилуулж, 2023 оны 10 сарын 19-ны өдрийн 501 тоот тогтоолоор батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгон үйл ажиллагааны орлогыг 13,138.4 сая төгрөг, нийт зардлыг 12,679.2 сая төгрөг, цэвэр ашгийг 442.3 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 13,847.5 сая төгрөгийн орлого, 12,618.6 сая төгрөгийн зардлыг гаргаж, 1,265.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 35 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 94.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд "Зөрөөний шинжилгээ"-г хийж гүйцэтгэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	22,267,836,16.47	26,419,701,172.81
1.1.2	Дансны авлага	23,013,913.87	98,807,415.42
1.1.4	Бусад авлага	-	120,522,000.00
1.1.6	Бараа материал	385,720,147.54	399,104,942.97
1.1.7	Урьдчилж төлсөн зардал / тооцоо	154,831,510.00	-
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	22,831,401,735.88	27,038,135,531.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,741,084,094.34	6,76,001,062.94
1.2.2	Биет бус хөрөнгө	292,945,861.64	396,956,726.54
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,034,029,955.98	7,164,957,789.48
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,865,431,691.86	34,203,093,320.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,167,197,253.41	4,531,712,418.33
2.1.1.3	Татварын өр	36,746,457.44	75,724,323.57
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,073,508,662.94	12,599,609,034.53
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	800,311,838.96	1,394,156,486.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	15,077,764,212.75	18,601,202,262.83
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,077,764,212.75	18,601,202,262.83
2.3	Эздийн өмч		
2.3.2	Өмч: – төрийн	8,159,338.00	8,159,338.00
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,337,339,884.99	1,337,339,884.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,454,791,998.45	6,454,791,998.45
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,791,896,742.67	7,606,120,321.41
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,787,667,479.11	15,601,891,057.85
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,865,431,691.86	34,203,093,320.68

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	9,372,303,198.09	13,373,467,744.97
2	Борлуулалтын өртөг	84,424,146.79	88,139,814.32
3	Нийт ашиг (алдагдал)	9,287,879,051.30	13,285,327,930.65
5	Хүүний орлого	11,451,502.31	473,987,346.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,618,444,914.30	12,530,465,450.46
12	Бусад зардал	120,000.00	3,400,000.00

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	38,823,289.07	7,289,619.76
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	250,473,186.30	108,773,806.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	970,062,114.68	1,341,513,252.31
19	Орлогын татварын зардал	66,931,413.70	75,724,323.57
20	Татварын дараах ашиг (алдагдал)	903,130,700.98	1,265,788,928.74
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	903,130,700.98	1,265,788,928.74
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,554,006,041.69	14,787,667,479.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(665,240,000.00)	(665,240,000.00)
Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	5,888,766,041.69	13,884,536,778.13
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	903,130,700.98	903,130,700.98
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,791,896,742.67	14,787,667,479.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(451,565,350.00)	(451,565,350.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,340,331,392.67	14,336,102,129.11
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	1,265,788,928.74	1,265,788,928.74
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	7,606,120,321.41	15,601,891,057.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,490,878,728.95	28,230,364,350.51
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	22,485,138,924.95	23,535,913,343.85
1.1.6	Бусад мөнгөн орлого	5,739,804.00	4,694,451,006.66
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,947,442,395.12	23,636,284,882.73

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	3,978,215,904.64	6,029,788,104.53
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,038,569,227.88	2,700,895,675.50
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,126,364,384.14	2,785,044,678.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,336,525.63	84,703,059.45
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,673,177,832.13	1,326,027,330.53
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,103,013,951.27	1,295,155,212.01
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	13,098,630.84
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,004,764,569.43	9,401,572,190.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,643,436,333.83	4,594,079,467.78
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,451,502.31	525,879,562.80
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	11,451,502.31	525,879,562.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	466,793,350.00	975,383,642.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	466,793,350.00	975,383,642.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(455,341,847.69)	(449,504,079.20)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	43,817,054.00	7,289,619.76
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	43,817,054.00	7,289,619.76
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,993,764.93	-
3.2.3	Валютын ханшийн зөрүү	4,993,764.93	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	38,823,289.07	7,289,619.76
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,126,917,775.21	4,151,865,008.34
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,140,918,389.26	22,267,836,164.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,267,836,164.17	26,419,701,172.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлтүүд	2022 он	2023 он		/мянган төгрөгөөр/	
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт					
1.1	Захиалагчийн хяналтын орлого	5,611,490.9	6,338,430.0	7,640,222.4	(1,301,792.4)	120.5
1.2	Нормчлолтой холбоотой орлого	415,000.9	620,000.0	626,791.6	(6,791.6)	101.1
1.3	Инженер техникийн ажилтны сургалтын орлого	329,802.5	570,000.0	412,325.6	157,674.4	72.3
1.4	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлого	59,833.3	130,000.0	97,366.2	32,633.8	74.9
1.5	Зураг төсөл, магадлалын орлого	2,275,741.8	2,600,000.0	2,679,621.6	(79,621.6)	103.1
1.6	Лабораторийн орлого	490,956.6	600,000.0	572,472.3	27,527.7	95.4

СНАГ-2024/105/НА-СТА-ТӨА



1.7	Бусад орлого (БАЖ, ХАБЭАхуйн дэвтэр, хүүгийн орлого)	200,928.7	2,280,000.0	1,818,655.5	461,344.5	79.8
	Нийт орлого	9,383,754.7	13,138,430.0	13,847,455.1	(709,025.1)	105.4
1.8	Үүнээс: Цэвэр борлуулалт	9,299,330.6	13,037,930.0	3,759,315.3	(721,385.3)	105.5
	Нийт зардал	8,702,869.0	12,679,190.7	12,618,605.3	60,585.4	99.5
2	Үүнээс: Удирдлагын зардал	348,733.8	459,358.3	481,084.8	(21,726.5)	104.7
3	Үйл ажиллагааны бус зардал	120.0	5,000.0	3,400.0	1,600.0	68.0
4	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	38,823.3	-	7,289.6	(7,289.6)	-
5	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	250,473.2	37,273.0	108,773.8	(71,500.8)	291.8
6	Татварын өмнөх ашиг	970,062.2	491,512.3	1,341,513.3	(850,000.0)	272.9
7	Цэвэр ашиг (алдагдал)	903,130.7	442,361.1	1,265,789.0	(823,427.8)	286.1
	Төсвийн төлбөрт нийт дүн	3,165,467.0	2,988,807.1	3,862,246.1	(873,439.1)	129.2
	а/ Орлогын татварт	186,710.8	49,151.2	75,724.3	(26,573.1)	154.1
	б/ НДШимтгэл	2,040,314.5	1,989,120.6	2,614,600.6	(625,480.1)	131.4
	в/ Хувь хүний орлогын албан татвар	855,959.5	858,235.3	1,121,988.1	(263,752.8)	130.7
	г/ Бусад татварт (газрын төлбөр, даатгал, ХХ-ээс суутгасан ОАТ, тээврийн хэрэгслийн татварт, ҮХХАТ)	82,482.3	92,300.0	49,933.1	42,366.9	54.1
9	Төрийн өмчийн ногдол ашигт	451,565.4	221,180.6	632,894.5	(411,713.9)	286.1
10	Нийт ажиллагсдын тоо	187	198	198	-	100.0
11	Нийт цалингийн сан	4,594,569.2	7,257,919.7	7,114,352.8	143,566.9	98.0
12	Нэг ажиллагчийн дундаж цалин	2,207.9	3,054.7	2,994.3	60.4	98.0
	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	373,317.7	621,254.0	566,586.8	54,667.2	91.2
14	Хөрөнгө оруулалт / өөрийн хөрөнгөөр	373,317.7	621,254.0	566,586.8	54,667.2	91.2
15	Нийт авлага	23,013.9	35,000.0	219,329.4	(184,329.4)	626.7
	Нийт өр төлбөр	15,077,764.2	16,500,000.0	18,601,202.3	(2,101,202.3)	112.7
	Үүнээс: 1. Нормчлолын сангийн бүрдүүлэлттэй холбоотой БХБЯ-нд өгөх өглөг	8,135,313.9	10,850,000.0	10,591,290.6	258,709.4	97.6
16	2. Экспертизийн ажлын хөлсний өглөг	799,009.4	850,000.0	1,394,131.1	(544,131.1)	164.0
	3. УТХО-той барилгуудын зохиогчид өгөх өглөг болон орон нутгийн ГБХБГ-т өгөх өглөг	3,085,649.5	2,850,000.0	4,472,434.3	(1,622,434.3)	156.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь "Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна" гэж зорилгоо тодорхойлж, барилга байгууламжийн норм, норматив боловсруулах, зураг төсөлд магадлал хийх, техникийн хяналт тавих, сургалт, судалгаа хийх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу чиг үүрэг бүхий Барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Салбарын хууль, тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Барилгын норм норматив, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- "Барилгын норм, нормативын сангийн хөрөнгөөр боловсруулах норм, норматив, төсөл арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу барилгын норм, дүрмийг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- Инженер техникийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах;
- Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх баяжилт хөтлөлт хийх, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Барилга, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлого зорилтыг сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх;
- Салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах;
- Улсын төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт гүйцэтгэх;
- Орон сууцны хувьчлал, мэдээллийн санг бүрдүүлэх, иргэд байгууллагуудыг мэдээллээр хангах;
- Салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон судалгаа, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах;
- Барилгын материал, хийц бүтээцийн дээжид сорилт шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар"-ыг татан буулгасантай холбогдуулан барилгын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий газар болж байгуулагдсан байна.

Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10. "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд 2022 онд хагас жил тутам үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг явуулж, хандив, үнэ төлбөргүй хүлээн авсан, худалдан авсан хөрөнгийг тухай бүр байгууллагын даргын шийдвэрээр холбогдох данс бүртгэлд үнэн зөв хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоол "Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

Барилгын хөгжлийн төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирлын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/89 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,337.7 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,267,836.2	26,419,701.2	4,151,865.0
Авлага	23,013.9	219,329.4	196,315.5
Бараа материал	385,720.1	399,104.9	13,384.8
Урьдчилж төлсөн зардал	154,831.5	-	(154,831.5)
Үндсэн хөрөнгө	7,034,030.0	7,164,957.8	130,927.8
Нийт хөрөнгө	29,865,431.7	34,203,093.3	4,337,661.6
Өр төлбөр	15,077,764.2	18,601,202.3	3,523,438.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,787,667.5	15,601,891.1	814,223.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	29,865,431.7	34,203,093.3	4,337,661.6

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, дансны өглөг, урьдчилж орсон орлого, эздийн өмчийн дансууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 4,151.9 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийсэн, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсний орлогоос шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 196.3 сая төгрөгөөр өссөн нь ХХБанканд байршуулсан хөрөнгийн баталгааны авлага 44.8 сая төгрөг, ЧД НДХ-ээс 4.2 сая төгрөг, Улс төрч агентлагаас 3.4 сая төгрөг, "Клауд би ай" ХХК-аас 2.2 сая төгрөг, Татварын байгууллагаас 10.3 сая төгрөг, ажилчдаас авах гадаад томилолттой холбоотой үүссэн авлага 28.6 сая төгрөг, "Интерактив" ХХК-аас авах 120.5 сая төгрөгийн авлагууд нь тайлант хугацаанд ажил үйлчилгээ, гэрээ хэлцэл бүрэн хэрэгжиж дуусаагүйгээс шалтгаалсан байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 154.8 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон нь "Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим программын хөгжүүлэлт"-ийн ажил, Вэб хуудсыг архивлаж, мэдээллийг ил тод нээлттэй болгох хөгжүүлэлтийн ажил, ERP хөгжүүлэлтийн ажил, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд бүрэн хийгдэж дууссантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 399.1 сая төгрөг болж оны эхнээс 13.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 73.1 сая төгрөгийн норм, дүрмийн ном, 100.2 сая төгрөгийн ном сэтгүүл, 94.4 сая төгрөгийн гарын авлага, 272.8 сая төгрөгийн шатах тослох материал, 1,029.0 сая төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 1,556.2 сая төгрөгийг төлөвлөгдсөн зардлын хэмжээнд зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 7,164.9 сая төгрөг болж 130.9 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 556 тоот, 2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 501 тоот тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 21 нэр төрлийн 82 ширхэг 794.3 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 324 болон 728 тоот тогтоолоор 101.5 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс 13.8 сая төгрөгийн компьютерыг балансаас балансад шилжүүлэн авсан, 213.5 сая төгрөгөөр төвийн байрны засвар, гадна дулааны болон цэвэр бохир усны шугамыг шинэчилж орлогоор авсан, ТӨБЗГ-ын 2023 оны 611 тоот тогтоолоор 211 нэр төрлийн 744 ширхэг 462.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг акталсан, мөн ТӨБЗГ-ын 2023 оны 26, 604 тоот тогтоолоор 2 нэр төрлийн 133.9 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг Засгийн газрын автобааз руу шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2023 оны

A/1/2360 албан бичгийн дагуу 4 нэр төрлийн 8,3 сая төгрөгийн хурлын тоног төхөөрөмж, A-1/1572 албан тоотоор 3 нэрийн 90.8 сая төгрөгийн 24 ширхэг компьютерыг тус тус БХБЯ-руу балансаас балансад шилжүүлсэн, үндсэн хөрөнгийн данснаас хангамжийн материалын данс руу 21.3 сая төгрөгийн залруулга хийсэн, тайлант онд байгуулсан 866.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл оны эхнээс 3,523.4 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 607 төсөл арга хэмжээнд барилгуудын зохиогчийн техник хяналт, зургийн зохиогч, экспертизийн ажлын төлбөрүүд нь ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүйгээс шалтгаалсан байна. Мөн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нормчлолын сангийн бүрдүүлэлтэй холбоотой БХБЯ-нд өгөх өглөг 10,850.0 сая төгрөг, экспертизийн ажлын төлбөрт өгөх өглөг 850.0 сая төгрөг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийн зохиогчид болон ГХБХБГ-т техник хяналтын зардалд өгөх 2,850.0 сая төгрөг нийт 16,500.0 сая төгрөгийг төлөвлөснөөс 18,601.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 15,601.9 сая төгрөг болж 814.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны ашгаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 556 тоот тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсныг 2023 оны 501 тоот тогтоолоор тодотгосон байна. Тайлант оны нийт орлогыг 13,138.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,679.2 сая төгрөгөөр, 442.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 775.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 13,847.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12,618.6 сая төгрөгийн зардал гарган, төлөвлөсөн ашгийг 823.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 12,65.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,847.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 709.0 сая төгрөг буюу 5.4 хувиар давж биелсэн нь захиалагчийн хяналтын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 12,679.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 60.6 сая төгрөг буюу 0.5 хувиар дутуу, зардлыг хэмнэж ажилласан байна.

Засвар, хөрөнгө оруулалтын зардлын 17 төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтын гүйцэтгэлийг цахимжуулах программ хангамж, зөөврийн болон суурин компьютер, скайнер, зйр кондэйшн, өнгөт болон хар принтер, таблет, ухаалаг дэлгэц, дрон, шахалтын бат бэх тодорхойлох пресс, барилгын салбарын мэдээллийн сангийн өргөтгөл тоног төхөөрөмж худалдан авахад 743.5 сая төгрөг, сургалтын танхимын засвар, байрны 2.3 давхрын болон бусад өрөөний засвар, байрны дээвэр усны хаялга, агааржуулалтын хоолой засах, гадна фасад хэсэгчлэн будах, гадна дулааны болон цэвэр бохир усны шугам шинэчлэхэд 213.5 сая төгрөг, нийт 956.9 сая төгрөгийг зарцуулсан.

Тайлант онд цэвэр ашиг 1,265.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 823.4 сая төгрөгөөр давж биелсэн нь захиалагчийн хяналтын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 онд 221.2 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээс 632,9 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн аудитор Д.Сугар, туслах аудитор Б.Энхчимэг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар нар, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор П.Цогзолмаа, аудитын менежер Б.Лхагвацэнд, Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 1/348 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 8,702.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 87.0 сая төгрөгөөр тогтоосон. Аудитын явцад дахин хянаж, 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал өмнөх оноос 3,919.2 сая төгрөгөөр буюу 45.0 хувиар өссөн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй түвшинг сонгосон суурь үзүүлэлт 12,622.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцож материаллаг байдлын түвшинг 126.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь шуудан холбооны зардал, засвар үйлчилгээний зардлыг хэмнэж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хамаарал бүхий 32 заалтыг мөрдөж ажилласан байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь тайлант хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 82.0 сая төгрөгийн өртөгтэй 4 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд

худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илэрсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 158 мэдээлэл байршуулахаас 157 мэдээллийг ил тод байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3.2 "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;", 6.3.3 "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;", 6.4.1 "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;" заалтуудтай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу байршуулсан зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 2023 онд 743.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 213.5 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан нь Засгийн газрын 124 дугаар тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"-той нийцэж байна.

Тус байгууллагад 27 тусгай мэргэжлийн хяналтын инженер ажилладаг, үүнээс 2 инженер нь бусад байгууллагад давхар ажил эрхэлсэн байна.

Энэ нь Барилгын инженерийн ёс зүйн дүрэм 5-р зүйлийн 5.8. "Олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг инженер болох төрийн байгууллагын ажилтан, зөвлөх, мэргэжилтэн нь тухайн байгууллагаас гадуур бусад төрийн болон хувийн байгууллагад ажиллах, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.", 4.5.11. "Инженер нь ажил олгогчдоо мэдэгдэхгүйгээр өөрийн мэргэшсэн салбар, мэргэжлээс гадуурх ажлыг хүлээж авахгүй.", 4-р зүйл "Инженерийн ёс суртахууны хэм, хэмжээ" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл "Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт", 18.1 "Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно." Заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид тусгай мэргэжлийн ажилтныг үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхлэхийг зогсоож, энэхүү үйлдлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар цалин, үндсэн хөрөнгө, төлөгдөөгүй удаж байгаа авлагын нөхцөл байдалтай танилцаж, дотоод хяналтыг үнэлж, жилийн эцсийн аудитын аудитын эрсдэлийг тодорхойлж, өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 97.2 сая төгрөгийн зөрчил арилгах 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувь биелсэн байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Төлбөрийн акт	1	21,349.7	1	21,349.7
Албан шаардлага	1	62,822.1	1	62,822.1	100.0
Зөвлөмж	3	12,996.2	1	12,996.2	100.0
Нийт дүн	2	97,168.0	6	97,168.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршсан бараа, ажил үйлчилгээг захиалгаар худалдан авсан эсэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 67 нэр төрлийн 64.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалттай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг бодит үнэ цэнээр шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөрчлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 67 нэр төрлийн 64.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны ертөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	64,669.2			1	64,669.2						
Дүн	1	64,669.2			1	64,669.2						

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/										
	Үүнээс										
	Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Шилэн дансанд мэдээлбэл зохих 158 мэдээлэл байршуулахаас 157 мэдээллийг ил тод байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан,	1	-	1	-							

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

тайлбарын 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	1	-		
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 82.0 сая төгрөгийн өртөгтэй 4 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.	1	82,023.8	1	82,023.8		
Тус байгууллагад 27 тусгай мэргэжлийн хяналтын инженер ажилладаг үүнээс 2 инженер нь бусад байгууллагад давхар ажил эрхэлсэн байна.	1	-				1
	2	82,023.8	1	82,023.8		1
	3	82,023.8	2	82,023.8		1
Дүн						
Нийт дүн						



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 дугаар сарын 15 № 493/А0150118

Улаанбаатар хот

СНАГ-2024/106/ЛА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд мэдээлэл зохих 158 мэдээлэл байршуулахаас 157 мэдээллийг ил тод байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтээлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3.2 "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт", 6.3.3 "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар", 6.4.1 "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заасыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа/, Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Г.Гантуул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ПХАГВАЦЭНД
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264450

Z:\Албан шаардлага\2024\0313\SNAG-18.Docx

0001081093



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 474/АД/СО/118
СААГ-2024/105/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 67 нэр төрлийн 64,669,244.60 /жаран дөрвөн сая зургаан зуун жаран есөн мянга хоёр зуун дөчин дөрвөн/ төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Цаашид хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа/, Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Г.Гантуул/ нэрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЗ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264380

Z:\Alban Shaardlaga\2024\0313\SAAG_10.Docx

0001081098



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 475/А0150118
СНАГ-2024/1105/НХ-СТА-70А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 82,023,810.00 /наян хоёр сая хорин гурван мянга найман зуун арван/ төгрөгийн өртөгтэй 4 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тус хэмжээ, нэг үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа/, Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Г.Гантуул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДХАГВАЦЭНД
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-261150

2: Албан Шаардлага 2024/0315 СНАГ-11.Docx

0001081095

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр